

ДОТООД АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН БАЙГУУЛЛАГА	ЦССҮТ
АУДИТЫН ДУГААР №	01
АУДИТЫН ТАЙЛАНГИЙН №	01/2025
АУДИТ ХИЙХ СТАНДАРТ	Нэгдсэн менежментийн тогтолцоо: • ISO 9001:2015 Чанарын менежментийн тогтолцоо-Шаардлага • ISO 45001:2018 ХЭМАБ-ын менежментийн тогтолцоо-Шаардлага
АУДИТЛҮҮЛЭГЧ	ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ
ОГНОО	2025 оны 09 дүгээр сарын 02-05-ны өдөр

Энэхүү аудитын тайлан нь аудитлүүлэгч ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВийн өмч бөгөөд албан ёсны зөвшөөрөлгүйгээр ашиглахыг хориглоно.

1. АУДИТЫН ҮЙЛЧЛҮҮЛЭГЧ, ШАЛГУУЛАГЧ	
1.1. Нэр, үйл ажиллагаа	
Нэр	ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ
Байгуулагдсан он	1963
Үндсэн үйл ажиллагаа	Цусны донорын сурталчилгаа, донор сонгох, цус, сийвэн, эс цуглуулах, шинжилгээ хийх, ЦЦБ үйлдвэрлэх, хадгалах, ЦЦБ эмнэлэгт захиалгын дагуу олгох
Бусад үйл ажиллагаа	Чанар, аюулгүй байдал, Халдварын сэргийлэлт хяналт, Сургалт, Эрдэм шинжилгээ, Захиргаа маркетинг, Санхүү бүртгэл, Инженер техник, Сувилахуй үйлчилгээ
Нийт ажилтны тоо	70
Салбар нэгж	СБД Цус цуглуулах төв, БЗД ЦЦТ, Дүнжингарав цус цуглуулах төв
Бусад мэдээлэл	-

1.2. Хаяг, холбоо	
Захирал	Б.Нарантуяа
Хаяг, байршил	БЗД 3-р хороо, Улсын хоёрдугаар төв эмнэлгийн хашаанд зүүн хойд талд Энхтайвны өргөн чөлөө-49
Утас, цахим хуудас, цахим шуудан	Утас: (976 – 11) – 70136504, 70112857 Факс: (976 – 11) – 70112857 Donor.mohs.mn, nctmmgl@gmail.com

2. АУДИТЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ	
2.1. Аудитын баг	
Багийн ахлагч	Э.Тунгалагтуяа
Багийн гишүүд	М.Цэрэндэжид Ж.Нармандах
Техникийн шинжээч	-

2.2. Аудитын талаарх ерөнхий мэдээлэл	
Аудитын зорилго	Цус, цусан бүтээгдэхүүн цуглуулах, шинжлэх, үйлдвэрлэх, хадгалах, олгох үйл ажиллагаанд хэрэгжүүлж буй ISO 9001:2015, ISO 45001:2018 стандартын дагуу үр нөлөөтэй хэрэгжиж байгаад аудит хийж, дүгнэлт гаргах
Аудитын шалгуур	ISO 9001:2015 “Чанарын менежментийн тогтолцоо-Шаардлага” ISO 45001:2018 “ХЭМАБ-ын менежментийн тогтолцоо-Шаардлага”
Аудит явуулах үед баримтласан	Төвийн дотоод аудит хийх журам

стандарт, норматив	
Аудит явуулсан хугацаа, огноо	2025.09.02-05-ны өдөр
Аудит явуулсан газар	ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ

4. АУДИТЫН ЯВЦ

Аудитын явцын талаарх товч мэдээлэл	Аудитын явц нь олон улсын стандартад заасан аргачлалын дагуу явагдсан болно. Үүнд: - Төвийн Ерөнхий захирлын тушаалаар аудитын баг томилогдсон. - Аудитын хамрах хүрээ, зорилго, шалгуурыг өнгөрсөн удаагийн аудитын зөвлөмжид тулгуурлан багаар хэлэлцэн тодорхойлсон. - Аудитын төлвөлгөө, маягтыг боловсруулж багаараа зөвшилцсөн. - Аудит хийх мэдээллийг ЦССҮТ-ийн хаалттай цахим группд байршуулж алба тасгуудад урьдчилан хүргэсэн. - Баримт бичигт дүн шинжилгээ хийж, аудитын мэдээллийг цуглуулж, баримтжуулах ажиллагааг явуулсан. - Аудитыг БЗД, СБД-ийн ЦЦТ-үүдийн үндсэн болон дэмжих алба тасгуудад хийлээ. - Аудитын үр дүн, дүгнэлтийг гаргаж, аудитын баг хэлэлцсэн. - Аудитын тайланг бичиж, зөвлөмжийн хамт төвийн захиралд танилцуулсан. - Аудитын тайлан, зөвлөмжийг шуурхай зөвлөгөөн дээр танилцуулан ЦССҮТ-ийн хаалттай цахим группд байршууллаа.
---	---

5. АУДИТЫН ҮР ДҮН

5.1. Сайн туршлага, давуу тал

Аудитын баг нь ISO 9001:2015 “Чанарын менежментийн тогтолцоо-Шаардлага” ISO 45001:2018 “ХЭМАБ-ын менежментийн тогтолцоо шаардлага” стандартад хийсэн аудитын үр дүнд дараах сайн туршлага, давуу талыг онцлон тэмдэглэж байна. Үүнд:

- Төв 2015 оноос Лабораторийн итгэмжлэл, 2017 оноос тогтолцооны 9001, 2018 оноос 18001 стандартуудыг хэрэгжүүлэх ажлыг эхлүүлж тогтвортой хадгалж ирсэн. 2022 онд ISO45001 станрт руу бүрэн шилжсэн.
- Үйл ажиллагаанд Donor info программыг бүрэн ашиглаж хэвшсэнээр, бүх үйл ажиллагаа бүрэн цахимд шилжсэн.

- Суурин төвүүдийн ажлын болон үйлчилгээний орчин сайн жил бүр нэмэлт засвар үйлчилгээг тогтмол хийн эрүүл таатай орчинг бүрдүүлж ажиллаж байна.
- Ажлын орчны болон үндсэн үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангах чиглэлээр улирал тутам удирдлагын баг тойрон үзлэг хийж, зөвлөмж өгч сайжруулалт хийж хэвшсэн.
- Ажилчдын амрах, чийрэгжүүлэх өрөөг ажиллуулж, цайны газрын хэсгийг үе шаттай ажиллуулж эхэлсэн
- Үндсэн үйл ажиллагаатай холбоотой мэдээлэлд өдөр тутам болон долоо хоног, сар, улирлаар дүн шинжилгээ хийж, сонирхогч талуудад мэдээлж хэвшсэн.
- Эмч ажилчдыг жил бүр ЭМ-ийн үзлэгт тогтмол хамруулж эрүүлжүүлэх ажлыг хийдэг.
- Томуу, гепатит В вирусын болон улаанбурхан, улаануудын вакцинжуулалтыг жил бүр тогтмол хийж эмч ажилчдыг хамруулдаг.
- Тусламж үйлчилгээтэй холбоотой болон бусад тохиолдлыг бүртгэл засч сэргийлэх үйл ажиллагаа сайн.
- Хүүхдийн өрөөг байгуулан тохижуулж ажиллагсдад ээлтэй орчинг бүрдүүлсэн.
-

5.2. Аудитаар тогтоосон сайжруулах санал, зөвлөмж

Аудитын баг нь аудитын үр дүнгээр дараах 3 сайжруулах шаардлагатай саналыг гаргасан. Үл тохирол илрээгүй. Үүнд:

6.1.2 Эрсдэл болон боломжуудад чиглэсэн арга хэмжээ, үр нөлөөг үнэлэх талаар төлөвлөнө- Эрсдлийн үнэлгээний үр дүнд үндэслэн эрсдлийг арилгах, бууруулах төлөвлөлт гарган үр дүнтэй арга хэмжээг хэрэгжүүлж байгаа ч цаашид нийт ажиллагсдын оролцоог хангах, сайжруулах;

7.1.2 Байгууллага нь ЧМТ-г үр нөлөөтэй хэрэгжүүлэх, үйл явцыг хянахад шаардлагатай хүний нөөцийг тодорхойлж хангана. –2025 оны 04 сараас тогтвортой ажиллах хүний нөөцийн ажилтангүй байна.

7.4 ЧМТ-нд хамаарах дотоод болон гадаад харилцааны асуудлыг байгууллага тодорхойлно. Байгууллагын гадаад ба дотоод харилцааны асуудлыг тодорхойлсон байна. Цаашид сонирхогч талуудад төвийн үйл ажиллагаа мэдээлэх үйл ажиллагааг сайжруулах;

5.3. Аудитаар тогтоосон үл тохирол

Аудитын баг нь аудитын үр дүнгээр стандартаар тогтоосон шаардлага нь биелэгдээгүй үл тохирлыг илрүүлсэн. Үүнд:

8.2 Онцгой байдлын болон бэлэн байдлын хариу арга хэмжээ. Галын хорыг цэнэглээгүй

6. АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитын баг нь аудитын дээрх үр дүнг үндэслэн дараах дүгнэлтийг гаргав.
Үүнд:

ЦССҮТ нь ISO 9001:2015 “Чанарын менежментийн тогтолцоо-
Шаардлага”, ISO 45001:2018 “ХЭМАБ-ын менежментийн тогтолцоо
Шаардлага”-ыг тус тус үргэлжүүлэн ХАНГАЖ байна.

ТАЙЛБАР:

1. Аудитлүүлэгч холбогдох алба, тасгууд нь аудитын багийн илрүүлсэн үл тохирлыг нэн яаралтай арилган, сайжруулах саналын дагуу үйл ажиллагаа хэрэгжүүлэн ажиллана.
2. Аудитын баг хэрэгжилтийн тайланг авч үр дүнг үнэлнэ.


ТАЙЛАН ГАРГАСАН:

АУДИТЫН БАГИЙН АХЛАГЧ:



Э. Тунгалагтуяа

АУДИТЫН БАГИЙН ГИШҮҮН:



М.Цэрэндэжид
Ж.Нармандах